



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/181

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар бүлгийн 2.4.1, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1023 дугаар захирамж, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт олон жил хуримтлагдсан хур хог хаягдлыг цэвэрлэж, дахин үүсэхгүй байх арга хэмжээ авах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|--------------------------|---------------|---|
| Үнэлгээний хорооны дарга | Г.Ууганбаяр | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга |
| Гишүүд: | Т.Энх-Амгалан | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн |
| | Т.Оюунтөгс | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| | Ц.Билгүүн | Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо 7 дугаар хороолол 21-28 тоотод оршин суугч иргэн |
| Нарийн бичгийн дарга | С.Аригуун | Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн |

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дүрэм, журмыг мөрдлөг болгон гүйцэтгэгчийг шалгаруулж ажиллахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



D:\back up_old_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

1110300516